




МАНАЙ ОРНЫ ХУВЬД МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЯМАР АРГА ХЭРЭГСЭЛ ТОХИРОМЖТОЙ ВЭ?

МУИС-ЭЭС, Санхүүгийн тэнхим
3 курсын оюутнууд:
Т. Цэрэндорж
Б. Сугарсүрэн
А. Баярчимэг


МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



Эдийн засгийн байдлаас хамаарч зорилт, арга хэрэгсэлээ сонгох тасралттай мөнгөний бодлогын туштай бус байдал нь бодлогын итгэлтэй байдлыг бууруулж улмаар урт хугацаанд эдийн засагт инфляцийн гажуудал бий болгохыг онолын хувьд анх Кидланд, Прескотт нар гаргаж Барро, Гордон нар цааш хөгжүүлэн улс орнууд удаан хугацаанд инфляцитай байгаа нь эрх баригчид дагаж мөрдөх дүрэмгүйтэй холбоотой бөгөөд ямар нэгэн дүрмийг дагахыг санал болгодог.



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



СУДЛАГДСАН БАЙДАЛ

Мөнгөний бодлогын зорилтын сонголт, үр дүнг үнэлэх, хэрэгслүүдийг сонгох, бодлогыг хэрэгжүүлэх онол практикийн асуудлууд-

Г. Бумчимэг

Мөнгөний бодлогын оновчтой хэлбэр- Ө. Баттулга

Монгол улсад Мөнгөний бодлого нь эдийн засагт нөлөөлөхдөө банкны зээлийн сувгаар мөн хөрөнгө оруулалтыг банкны зээл гэж төлөөлүүлбэл уламжлалт зээлийн хүүгийн сувгаар дамжин нөлөөлдөг.

- Нээлттэй эдийн засгийн загварт мөнгөний бодлогын Тейлорын дүрмийг ашигласнаар загварын шийдэлд хүрэх боломжтой
- Тейлорын дүрэм нь хэдийгээр бусад орнуудын жишээн дээр сайн таардаг боловч Монгол улсын хувьд тохирохгүй. Энэ нь авч үзсэн үед бусад шокын нөлөөлөл маш их байснаас зээлийн хүүгийн түвшин бодлогын шинж чанартайгаар ихээхэн хэлбэлзэл байсантай холбоотой.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГСЛҮҮД

ВАЛЮТЫН ХАНШИЙГ
ОНИЛСОН

МӨНГӨНИЙ
АГРЕГАТУУДЫГ
ОНИЛСОН

ИНФЛЯЦИЙГ
ОНИЛСОН



ВАЛЮТЫН ХАНШИЙГ ОНИЛСОН

ДАВУУ ТАЛ

- Экспортлодог бүтээгдэхүүний үнийн хяналтаар дамжуулан инфляцийг хязгаарлах боломжтой
- Валютын ханшийн зорилт нь мөнгөний бодлогын тууштай бус байдлыг хязгаарладаг. Валютын ханш сулрахад-хумих бодлого, чангархад-тэлэх бодлого автоматаар явуулдаг→Мөнгөний бодлогын боловсруулалтын эргэлзээтэй байдлыг бууруулдаг

СУЛ ТАЛ

- Уягч валютаас хамааралгүй дотоодын шокуудад хариу үйлдэл үзүүлэх чадвар буурдаг → Уягч валюттай улсын шокууд шууд нөлөөлдөг
- Хараат байдал→ Улс валюттай шууд нөлөөлж чадахгүй, уягч валютаар дамжуулан нөлөөлнө




МӨНГӨНИЙ АГРЕГАТУУДЫГ ОНИЛСОН

ДАВУУ ТАЛ

- Төв банк мөнгөний бодлогоор дотоодын асуудлуудыг бүрэн хянадаг→Бусад орнуудын эдийн засгаас хараат бус байна.

СУЛ ТАЛ

- Мөнгөний зорилтот агрегат болон эцсийн зорилгын хувьсагчийн хамаарал тодорхой биш байх нь мөнгөний бодлогын тодорхой байдлыг хангах болон олон нийтэд мөнгөний бодлогын талаар мэдээлэхэд хүндрэлтэй байна.



ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

- ✘ *Валютын ханшийг онилсон-Англи болон Франц улсууд үндэсний валютаа Германы үндэсний валют болох МАРКтай уясанаар инфляцийн түвшинээ бага хэмжээнд барьж чадсан байна.*
- ✘ *Мөнгөний агрегат-Канад улс 1975-1982 онд М1агрегатыг, харин Англи улс 1973-1987 онд М3 агрегатыг ашиглаж байжээ.*

ИНФЛЯЦИЙГ ОНИЛСОН

ДАВУУ ТАЛ

- Инфляцийг тодорхой түвшинд барих нь ирээдүйн тодорхой бус байдлыг багасгадаг
- Төв банкны хариуцлага нэмэгддэг ба бусад зорилгуудтай харьцуулахад амар ойлгогдохуйц
- Зорилтот түвшинээс илүү гарсан тохиолдолд богино хугацаанд хүүг өсгөн эргэн зорилтот түвшиндээ барих боломжтой

СУЛ ТАЛ

- Богино хугацааны сигнал өгөхөд дутагдалтай. Гэнэтийн нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэхдээ удаан
- Инфляцийн бага түвшин→Хатуу бодлого→ДНБ-ий алдагдал, эдийн засгийн өсөлт буурна



ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

- ✘ Канад улс 1991-1994 онд 2-4%, 1994-1996 онд 1.5-3.5%, 1996 оноос 1-3% инфляцийн зорилтот түвшинтэй байсан ба 1991 онд 5-с дээш байсан инфляци 1995 оноос зорилтот түвшиндээ барьж чадсан байна.
- ✘ Англи улс 1992-1997 онд инфляцийн 1-4%, 1997 оноос 2.5% бага зорилтот түвшингтэй байсан ба 1996 он хүртэл инфляци 2.5 их байсан ба 1997 оноос зорилтот түвшиндээ байна.

МАНАЙ ОРНЫ ХУВЬД ЯМАР БОДЛОГО ТОХИРОМЖТОЙ ВЭ?

Валютын ханшны бодлого
хэрэгжүүлж болохгүй шалтгаан

- ОУВС-ийн гишүүнээр элсэхдээ эрэлт, нийлүүлэлтээс хамаарсан хөвөгч валюттай байна гэж гэрээ заасан
- Монгол улс шиг гадаадын эдийн засгаас хамааралтай оронд уг бодлого нь ТБ-ны уягч валюттай орны мөнгөний бодлогоос хараат → Тус мөнгөний бодлогыг дагах

Мөнгөний агрегатуудыг
онилсон мөнгөний бодлого
хэрэгжүүлж болохгүй шалтгаан.

$$M*V=P*Q$$

- Мөнгөний агрегатуудыг онилсон бодлого хэрэгжүүлэх гол хөшүүрэг нь "V" буюу мөнгөний эргэлтийн хурд тогтмол байвал зохимжтой бөгөөд Монгол улсын хувьд мөнгөний эргэлтийн хурд тогтворгүй байдаг учир уг бодлогыг хэрэгжүүлэх боломжгүй юм



ИНФЛЯЦИЙГ ОНИЛСОН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

Үзүүлэлтүүд	2011	2012	2013	2014
ДНБ-ий бодит өсөлт	10.80	16.60	14.80	15.40
Уул уурхай	10.60	49	24.60	26.10
Уул уурхай бус	10.80	9.40	11.80	11.70
Нэг хүнд ноогдох ДНБ, Мянган Төгрөгөөр	3603.30	4870.00	5694.50	6684.10
Нэг хүнд ноогдох ДНБ, Доллараар	2948.00	4105.90	4998.60	6084.20
Хэрэглээний үнийн өөрчлөлт	9.70	9	8	8
Гадаад худалдааны тэнцэл	-603.75	436.20	1810.50	2213.40
Экспорт	3951.05	5903.30	7775.20	9196.40
Өсөлт, хувиар	36%	49%	32%	18%
Импорт	4554.80	5467.20	5964.70	6983.00
Өсөлт, хувиар	39%	20%	9%	17%



ИНФЛЯЦИЙГ ОНИЛСОН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ

Эдийн засгийн хэтийн төлвөөс харахад эдийн засгийн огцом өсөлт харагдаж байна. Эдийн засаг нь огцом өснө гэдэг нь эдийн засаг нь огцом унах магадлалыг нэмэгдүүлдэг ба төв банкны зорилго нь ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХАНГАХ ЯВДАЛ юм.

Инфляцийг онилсон бодлого хэрэгжүүлснээр тодорхой бус байдлыг бууруулж, урт хугацаанд хөрөнгө оруулалт татах боломжтой → Санхүүгийн тогтвортой байдал сайжирна.



ТӨВ БАНКИНД ИТГЭХ ИТГЭЛ

- ✘ Төв банкны явуулж буй мөнгөний бодлогын үр дүн нь иргэдийн итгэх итгэлээс хамааралтай. Төв банк нь ямар ч сайн бодлого явуулсан байлаа иргэд итгэхгүй бол энэ нь үр дүнгүй юм.
- ✘ Япон улсад иргэд нь инфляцийн түвшин өсөхгүй гэж боддог учир хүлээлтийн инфляци бий болдоггүй.

ИНФЛЯЦИЙГ ОНИЛОХ БОЛДОГО

- ✘ 2006 он хүртэл мөнгөний агрегатуудыг онилсон бодлого хэрэгжүүлсэн
- ✘ 2008 онд инфляцийг онилсон мөнгөний бодлого хэрэгжүүлэх гэж оролдсон ч
- ✘ 1. Эдийн засгийн хямрал
- ✘ 2. Урьдач нөхцлүүд бүрдээгүй улмаас бүтэлгүйтсэн
- ✘ Бид ахиж дэвших ёстой

ИНСТИТУЦИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

1. Төсвийн давамгайлал

ДНБ эзлэх хувиар (Засгийн газрын зардал их байх тусам төсвийн давамгайлал их бага байх тусам сайн бие даасан байдал сайн)

2. Улсын өр

Өрийн дарамт хэр байгааг харуулна төв банкинд дарамт бага тусам сайн

3. Төсвийн тэнцэл

Төсвийн алдагдал хэр байгааг харуулна алдагдал бага байх нь сайн учир нь төв банканд алдагдлийг санхүүжүүлэх нь дарамт болдог


4. Төв банкны бие даасан байдал



ДАРААХ ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛАХАД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРДАЛ ИХ БАЙГАА НЬ САНГИЙН ТЭЛЭХ БОДЛОГО ЯВУУЛЖ ХАРИН МОНГОЛ БАНКНЫ ЗҮГЭЭС МӨНГӨНИЙ ХАТУУ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА НЬ ЗОХИМЖГҮЙ ЮМ.

Улс орнууд	Шинэ Зеланд	Чех	Румын	Тайланд	Польш	Филиппин	Монгол
Засгийн газрын зардал /ДНБ	17.2	30.9	34.1	19.7	28.4	16.8	33.06*
Төсвийн тэнцэл/ДНБ	-1.7	-1.0	-3.2	-1.1	-2.2	-4.0	10.98*
Улсын өр/ДНБ	50.0	13.0	26.5	58.0	39.8	87.0	39,54*





П. Сарангуа

2010 оны “Төв банкны бие даасан байдал” судалгаанд манай төв банкны LVAW индекс 1996 оны хуулинд 0.68 байсан бол 2010 оны шинэчилсэн найруулгаар 0.47 болсон нь төв банкны бие даасан байдал муудсаныг харуулж байна

Төв банк нь хараат бус байвал, инфляцийн түвшин доогуур гэсэн олон улсын туршлага байна.



ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЭЦ

1. Валютын ханшийн мэдрэмж

- ХҮИ-д үзүүлэх нөлөөллийг харуулна, мэдрэмж их байвал импортоор дамжин дотоодын үнэд нөлөөлдөг учир бага тусмаа сайн байна.

2. Барааны үнийн мэдрэмтгий байдал

- Экспортын голлох бүтээгдхүүний дэлхийн зэх зээлд дээрх өөрчлөлт дотоодын ХҮИ –д хэрхэн нөлөөлж байгааг харуулна.ДНБ-д өндөр хувь эзэлж байвал инфляцид өртөх магадлал өндөр.

3. Долларжилт

- Долларжилт их байвал валютын уян хатан ханшийн системд төгрөгийн ханш илүү тогтворгүй байна



Улс орнууд	Шинэ Зеланд	Тайланд	Филиппин	Румын	Польш	Чех	Монгол
Валютын ханшийн өөрчлөлтийн мэдрэмж		0,02		0,37	0,5	0,30	0,52
Барааны үнийн мэдрэмж	10-20	10-20	2,5-5	2,5-5	2,5-5	2,5-5	21+
Долларжилтын түвшин		25	40,70	40	16	12	32,5*

- Инфляцийг үр дүнтэй хянахын тулд экспортын голлох бүтээгдхүүний үнэ ханшаас мэдрэмтгий биш долларжих явц бага байвал хүүгийн сувгийг сайжруулж эсэргээрээ валютын ханшийн сувгаар дамжих гадны шокын нөлөөг бууруулдаг.
- Долларжилт их байвал дотоод зээлийн хүүгийн бодлогын нөлөөнөөс илүү валютын ханшийн сувгаар илүү нөлөөлнө.



САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Хөрөнгийн захын хөрөнгөжилт

- ДНБ-д эзлэх хувиар, их байх тусам хөрөнгийн зах сайн хөгжсөн байна гэж үзнэ.

Хөрөнгийн захын эргэлтийн харьцаа

- Эргэлт их байх тусам хөрөнгийн зах хэр идэвхтэй байгааг харуулна, эргэлт сайн байвал хөгжил сайн.

Уг бодлогын явуулахын тулд санхүүгийн салбар доод тал нь боломжийн хэмжээнд хөгжсөн байвал инфляцийг зорилт болгосон бодлогыг явуулахад илүү үр дүнтэй, учир нь уг бодлогын гол арга хэрэгсэл нь бодлогын хүү байдаг учраас мөнгөний бодлогын шилжих механизмийн үр нөлөө сайн байхын тулд банкны систем тогтвортой , хөрөнгийн зах зээл сайн хөгжсөн байх хэрэгтэй юм.



Уг бодлогын явуулахын тулд санхүүгийн салбар доод тал нь боломжийн хэмжээнд хөгжсөн байвал инфляцийг зорилт болгосон бодлогыг явуулахад илүү үр дүнтэй, учир нь уг бодлогын гол арга хэрэгсэл нь бодлогын хүү байдаг учраас мөнгөний бодлогын шилжих механизмийн үр нөлөө сайн байхын тулд банкны систем тогтвортой , хөрөнгийн зах зээл сайн хөгжсөн байх хэрэгтэй юм.

Улс орнууд	Шинэ Зеланд	Чех	Румын	Тайланд	Польш	Филиппин	Монгол
Хөрөнгийн зах зээлийн хөрөнгөжилт ДНБ-д эзлэх хувиар	13.8	15.8	9,80	4,00	31,41	50,82	14,00*
M2/ДНБ		68,00	36,00	23,06	103,12	55,94	56,6*
Хувийн зээл/ ДНБ	68.,9	65,71	23,60	8,74	101,27	39.00	39,54*



ТЕХНИКИЙН БҮТЭЦ

- ✘ Инфляцийг таамаглах загварчлах байх хэрэгтэй . Ингэснээр инфляцид нөлөөлөх бүхий хүчин зүйлийг тооцон хэтийн төлвийг таамаглахыг тулд тоон мэдээ чанартай байх хэрэгтэй. Манай улсын хувьд саяхныг хүртэл SIMOM загварыг хэрэгжүүлж байсан бол одоогийн байдлаар DSGE загварыг боловсруулсан нь техник тооцооллын хувьд дэлхийн жишигт ойртож буйг харуулж байна.
- ✘ МУИС 1-ийн зааланд МБ-ны эдийн засагч Даваадалай танилцуулсан



ДҮГНЭЛТ

- ✘ Мөнгөний бодлогын дээрх гурван арга хэлбэр нь А,Б,В гээд зэрэгцээд байж байдаг сонголт биш бөгөөд эдийн засгийн нөхцөл байдалдаа зохицуулж сонгох хэрэгтэй.
- ✘ Монгол улсад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдээс валютын ханшийг онилсон бодлого, мөнгөний агрегатуудыг онилсон бодлого тохиромжгүй бөгөөд өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд тохирох мөнгөний бодлого нь инфляцийг онилсон мөнгөний бодлого юм.

- ✘ **ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХАНГАХ ЯВДАЛ.**

Инфляцийг онилсон бодлого хэрэгжүүлснээр тодорхой бус байдлыг бууруулж, урт хугацаанд хөрөнгө оруулалт татах боломжтой → Санхүүгийн тогтвортой байдал сайжирна.

- ✘ Дунд, Урт хугацаанд мөнгөний бодлого, сангийн бодлогыг уялдуулах хэрэгтэй ба нэгнийхээ хийсэн алдааг нөгөө нь залруулж байгаа нь учир дутагдалтай юм.
- ✘ Мэдээллийн ил тод нээлттэй байдал, төв банкинд итгэх итгэлийг сайжруулах нь мөнгөний бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тун чухал юм.
- ✘ Төв банкны хараат байдал LVAW индексээр буурсан нь муу юм
- ✘ Өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд урьдач нөхцлүүд бүрэн хангагдаагүй хэдий ч ирээдүйд бүрдүүлэх боломжтой юм. Энэхүү бодлогоруу 4-5 жилдээ шилжих боломжтой гэж таамаглаж байна.




САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- ✘ Төв банкны үндсэн зорилт нв үндэсний мөнгөн тэмдэгийг тогтвортой байдлыг хангахад оршино гэдэг боловч боломжгүйн гурвал судалгаагаар хангагдахгүй гэдэг нь тогтоогдсон байдаг учир уг зорилтыг үнийн тогтвортой байдлыг хангах гэж өөрчлөх нь зүйтэй.
- ✘ Төв банкиг шүүмжилсэн иргэд, аж ахуй нэгж, улс төрийн зүтгэлтнүүд гэх хүмүүст хариу үйлдэл үзүүлэх албагүй юм.
- ✘ Монгол улсын хувьд инфляцийг онилсон мөнгөний бодлого хэрэгжүүлэхийн тулд бидний дурьдсан урьдач нөхцлүүдээ сайжруулах хэрэгтэй.
- ✘ Мөнгөний бодлогын хэрэгжүүлэгчид зорилгодоо хүрч чадахгүй бол хариуцлага хүлээх, хэрвээ ийм тогтолцоо байвал улс төрөөс хараат бус байна.



EVIEW 6.0



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ✘ Frederic S. Mishkin. “The economics of money, banking, and financial markets.” Chapter 16.
- ✘ П. Сарангуа “Төв банкны бие даасан байдал” 2010
- ✘ Ч. Отгочулуу “Тогтворгүйн гурвалжин ба Монгол”
- ✘ IMF-ийн судалгааны ажлууд
- ✘ Д. Энхзаяа “Монгол улс инфляцийг онилох бодлого баримтлах хэрэгтэй” 2008
- ✘ www.Mongolbank.mn
- ✘ Интернет эх үүсвэр
- ✘ Төв банкны тухай хууль
- ✘ Статистикийн бюллетэнь
- ✘ Төв банкны тухай хууль

АНХААРЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА